



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

### Журам өөрчлөн батлах тухай

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020 оны 3 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төвсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настанд холбогдох хуульд заасан дэмжлэг үзүүлэх “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ахмадын сангийн зөвлөлийн дарга /хурандаа Ц.Ганзориг/, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны А/47, 2017 оны А/339, 2018 оны А/445 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

00001177



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН САН  
БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

*Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Энэхүү журмын зорилго нь Онцгой байдлын байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Ахмадын сан" /цаашид "сан" гэх/ байгуулах, түүнийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Ахмад настны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" /цаашид "Нийтлэг журам" гэх/-ын хүрээнд Онцгой байдлын байгууллагын нийт цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө бүхий санг байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвт тусгана.

1.3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг Ахмадын сангийн зөвлөл, ахмадын сангийн дэд зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

*Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт*

2.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Ахмадын сангийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагчийн тушаалаар Ахмадын сангийн дэд зөвлөл /цаашид "Дэд зөвлөл" гэх/-ийг байгуулан ажиллуулна.

2.2. Зөвлөлд Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, тус нэгжийн төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Захиргааны, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн дарга, тус нэгжийн хүний нөөцийн судалгаа, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

Дэд зөвлөлд Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад тухайн нэгжийн орлогч дарга, ахлах нягтлан бодогч, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн байна.

2.3. Зөвлөл нь Онцгой байдлын байгууллагын нийт цалингийн сангийн 3 хүртэлх хувийг дараа жилийн төсөвт суулгах асуудлыг хариуцна.

2.4. Төсөвт суусан сангийн нийт мөнгөн хөрөнгийг Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тоог харгалзан 3 хүртэл хувийн мөнгөн хөрөнгийг тухайн байгууллагад шилжүүлнэ.

*Тайлбар: "албан хаагчдын тоо" гэж тухайн байгууллагын төрийн тусгай болон төрийн үйлчилгээний нийт алба хаагчдыг ойлгоно.*

2.5. Сангийн мөнгөн хөрөнгийг Нийтлэг журмын 3.1-т<sup>1</sup> заасан арга хэмжээнд зарцуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"

<sup>1</sup> 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна:

3.1.1. байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох;

3.1.2. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах;

3.1.3. нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх;

3.1.4. хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;



3.1.5. шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;

3.1.6. эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх;

3.1.7. ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;

3.1.8. ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.9. амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангүй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж үзүүлэх.

2.6. Сангийн мөнгөн хөрөнгийг зарцуулах асуудлыг ахмадын хороо, зөвлөлийн саналыг үндэслэн Зөвлөл, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад Дэд зөвлөлөөр шийдвэрлэж, даргын тушаалаар баталгаажуулна.

2.7. Энэхүү журмын 2.6-д заасан арга хэмжээнд сангийн мөнгөн хөрөнгийг зарцуулах хувь хэмжээг жил бүрийн эхэнд Зөвлөлийн саналыг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын дарга тогтооно.

2.8. Энэхүү журмын 2.7-д заасан сангийн мөнгөн хөрөнгийг зарцуулах хувь хэмжээг тогтоохдоо Нийтлэг журмын 3.2-т<sup>2</sup> заасныг баримтална.

2.9. Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын ахмадын хороо болон зөвлөлийн удирдлага ахмад настанд тусламж, дэмжлэг хүссэн албан ёсны саналыг Зөвлөлд, Дэд зөвлөлд гаргана.

*Тайлбар: "албан ёсны санал" гэж Нийтлэг журмын 3.4-т<sup>3</sup> заасан хүсэлтийг тухайн ахмадын хороо, зөвлөлөөр хэлэлцэн гаргасан саналыг ойлгоно.*

2.10. Сангийн мөнгөн хөрөнгийг энэхүү журмын 1.2-т заасны дагуу бүрдүүлэхээс гадна Нийтлэг журмын 2.1-т<sup>4</sup> заасан эх үүсвэрээс холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх асуудлын Зөвлөл хариуцсан гүйцэтгэнэ.

#### *Гурав. Тайлан, тавих хяналт*

3.1. Дэд зөвлөл нь жил бүрийн 2 дугаар сарын 01-ний өдөр өөрийн байгууллагын сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайланг харьяалах ахмадын хороон болон зөвлөлд танилцуулан тайланг Зөвлөлд ирүүлнэ.

Зөвлөл нь Онцгой байдлын ерөнхий газрын сангийн зарцуулалтыг тус газрын дэргэдэх ахмадын хороонд тайлагнана.

3.2. Зөвлөл нь тухайн жилд Онцгой байдлын байгууллагын хэмжээнд зарцуулсан болон үлдэгдэл мөнгөн хөрөнгийн судалгааг нэгтгэн гаргаж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд тайлагнана.

3.3. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан бүтцийн нэгж холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

<sup>2</sup> 3.2. Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, төсвийн шууд ерөнхийлөн захирагч энэхүү журмын 3.1.2, 3.1.8-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 20 хувиас багагүй байхаар тогтоож, байгууллагын төсөв болон дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

<sup>3</sup> 3.4. Сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт болон бусад шаардлагатай холбогдох баримт бичгийг бүрдүүлэн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлд хүсэлт гаргана

<sup>4</sup> 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, төсөвт байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвөөс цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;

2.1.2. сангийн үйл ажиллагаанаас олох орлого;

2.1.3. сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;

2.1.4. гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;

2.1.5. сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого;

2.1.6. бусад эх үүсвэр.